

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
<p>АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ</p> <p>2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр</p>		<p>4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл</p> <p>4.3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.</p> <p>6.2. Энэ хуулийн 5.1; 5.2; 5.3; 5.8; 5.9; 5.10-т заасан журмыг зөрчиж үйлдвэрлэсэн буюу импортолсон, эсхүл хяналтын шинжилгээ хийлгээгүй согтууруулах ундааг худалдаа, үйлчилгээнд гаргахыг хориглоно.</p> <p>6.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, мөн зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах байршлаа өөрчлөхийг хориглоно.</p> <p>6.4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.</p> <p>6.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.</p>